



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/284

Ховд

Барилгын захиалагчийн хяналтын талаар
авах арга хэмжээний тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 83 дугаар “Барилгын захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт захиалагчийн хяналт хийхэд шаардлагатай гэрээгээр авч ажиллуулах инженер, лабораторийн лаборантын цалин, ажлын хувцас, автомашины урсгал завсарын зардлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлсүгэй.

2. Гэрээгээр авч ажиллуулах инженер, лаборантын орон тоо, цалингийн сүлжээг нэгдүгээр, ажлын хувцас, автомашины урсгал завсарын зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Гэрээт ажилтнуудын 2022 оны цалин 20,184,448 төгрөг (хорин сая нэг зуун наян дөрвөн мянга дөрвөн зуун дөчин найм), ажлын хувцас, автомашины урсгал завсарын зардал 5,840,000 төгрөг (таван сая найман зуун дөчин мянга), нийт 26,024,448 төгрөг (хорин зургаан сая хорин дөрвөн мянга дөрвөн зуун дөчин найм)-ийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

- 4. "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж, ажлын тайланг хагас, бүтэн жилээр ирүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Дөлбадрал)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ



180

Аймгийн Захиргаа 2023 оны
08 дугаар сар 09-ний өдрийн
А/284 дүгээр захирамжийн
нэгдүгээр хавсралт

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ ГЭРЭЭГЭЭР
АЖИЛЛУУЛАХ ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТНЫ ОРОН ТОО, ЦАЛИНГИЙН
ХЭМЖЭЭ

№	Авч ажиллуулах инженер	Орон тоо	Цалингийн сүлжээ	Цалингийн хэмжээ (төгрөг)	Урамшуулал	Ажиллах хугацаа (8 сар)
1	Барилгын хяналтын инженер	1	ТҮ-7-5	766481	20 хувь хүртэл	7358216
2	Дэд бүтцийн хяналтын инженер	1	ТҮ-7-5	766481	20 хувь хүртэл	7358216
3	Лабораторийн лаборант	1	ТҮ-3-5	569585	20 хувь хүртэл	5468016
Нийт дүн						20184448

-оОо-

12



Аймгийн Засаг дарга 2022 оны
 05 дугаар сарын 09-ний өдрийн
 А/284 дүгээр захирамжийн
 хоёрдугаар хавсралт

ХУДАЛДАН АВАХ БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТООЦОО

№	Бараа, ажил үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт дүн
1	Барилгын хяналын ажлын хувцас	ком	8	380000	3040000
2	Захиалагчийн хяналт хийх суудлын автомашины засвар үйлчилгээ	багц	2	1400000	2800000
Нийт дүн					5840000

-oOo-